

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ

2017 ОНЫ 1 ДҮГЭЭР САРД

Нийслэл, дүүргийн нийт 10 Засаг даргын тамгын газар (ЗДТГ) Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаад иргэний нийгмийн байгууллагууд мониторинг хийж байна. Хуулиар нийтэд ил болгох ёстой мэдээллээс зургааг нь сонгон авч ЗДТГ-ууд 2017 оны 1 дүгээр сарын туршид эдгээр мэдээллийг хэрхэн нийтэлж байгааг ажиглав.

АЖИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ҮР ДҮН

ЗДТГ-ууд Төрийн санд бүртгэгдсэн 5 сая төгрөгөөс дээш дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ бүрэн гүйцэд ил тод болгох байдал хангалтгүй хэвээр байна.

Энэхүү мониторингоор Шилэн дансны тухай хууль (ШДХ)-ийн дагуу нийслэл, дүүргүүдийн ЗДТГ 2017 оны 1 дүгээр сард ил тод болгосон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн тухайн сарын дансны хуулгатай харьцуулж үзэв.

1 дүгээр сарын дүн мэдээгээр зөвхөн хоёр дүүргийн ЗДТГ Төрийн санд бүртгэгдсэн нийт гүйлгээгээ 100% ил тод болгожээ (Тайлбар 2-ыг үзнэ үү).

100% Хан-Уул, Баянгол дүүрэг

90.0% Сүхбаатар дүүрэг

88.2% Чингэлтэй дүүрэг

84.6% Сонгинохайрхан дүүрэг

80.0% Баянзүрх дүүрэг

50.0% Нийслэлийн ЗДТГ

46.7% Налайх дүүрэг

40.0% Багахангай дүүрэг

0% Багануур дүүрэг

Тайлбар: 1 🏠 = 10%

ЦАЛИНГААС БУСАД 5 САЯ ТӨГРӨГӨӨС ДЭЭШ ҮНИЙН ДҮН БҮХИЙ ОРЛОГО, ЗАРЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

Нийт гүйлгээний тоо

18 Сүхбаатар дүүрэг

15 Чингэлтэй дүүрэг

14 Хан-Уул дүүрэг

12 Баянзүрх дүүрэг

11 Сонгинохайрхан дүүрэг

9 Баянгол дүүрэг

7 Налайх дүүрэг

5 Багануур дүүрэг

2 Нийслэлийн ЗДТГ, Багахангай дүүрэг

ШДХ-ийн 6.4.5-р заалтын дагуу ил болгох цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг бүх ЗДТГ нийтэлснээс СБД хамгийн олон буюу 18 мэдээлэл ил болгожээ (Тайлбар 1-ийг үзнэ үү).

Гүйлгээнд холбогдох шийдвэрийн тоо

5 Багануур дүүрэг

2 Чингэлтэй дүүрэг

0 Бусад

Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээний шийдвэрийг хоёр ЗДТГ л нийтэлжээ.

5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийн тоо

4 Хан-Уул, Сүхбаатар дүүрэг

3 Чингэлтэй дүүрэг

2 Сонгинохайрхан дүүрэг

0 Бусад

ШДХ-ийн 6.4.4-р заалтын дагуу ил болгох 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг зөвхөн дөрвөн ЗДТГ нийтэлжээ (Тайлбар 1-ийг үзнэ үү).

Тайлбар: 1 🏠 = 1 мэдээлэл

20%



Хуулийн дагуу 1 дүгээр сарын 10-ны дотор нийтэд ил тод болгох ёстой тухайн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийслэлийн хэмжээнд Налайх, Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ууд л нийтэлжээ.

Нийслэл, дүүргийн ЗДТГ-ууд 2017 оны батлагдсан төсвөө хуулийн дагуу 1 дүгээр сарын 10-ны дотор, 2017 оны 1-р сарын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээгээ 2 дугаар сарын 8-ны дотор бүгд нээлттэй мэдээлжээ.

Дүн мэдээнд хамаарах тайлбар:

- 5 сая төгрөгөөс дээш дүнтэй худалдан авалт болон гүйлгээний тоог гаргахдаа ЗДТГ-ын шилэн дансанд нийтлэгдсэн мэдээллээс зөвхөн үүнд хамааралтайг түүвэрлэж авсан болно.
- Төрийн сангийн гүйлгээнээс ил тод болгосон хувийг үнэлэхдээ зөвхөн энэ оны 1 дүгээр сард хамаарах 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт болон гүйлгээг тооцсон болно.

АШИГЛАСАН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
- ЗДТГ-ын цахим хуудас

- ЗДТГ-ын мэдээллийн самбар
- Сангийн яамны Төрийн сангийн дансны хуулга

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагууд мониторинг хийж дүнг сар бүр мэдээлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.